



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/482

Улаанбаатар хот

「Хан-Уул дүүргийн 118 дугаар сургуулийн」  
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 13,281,200 /арван гурван сая хоёр зуун наян нэгэн мянга хоёр зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 118 дугаар сургууль /Ц.Мөнхтөр/-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 6 нэр төрлийн нийт 13,281,200 /арван гурван сая хоёр зуун наян нэгэн мянга хоёр зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 118 дугаар сургууль /Ц.Мөнхтөр/-д үүрэг болгосугай.

3.Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001217

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдалгын газрын  
даргын 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн  
.../482 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 118 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр төрөл	Ашигласан жил	Хэмжих нэгж	тоо ширхэг	нэгж үнэ	бүгд үнэ	элэгдэл	Үлдэх өртөг	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХХК-ын хурлын шийдвэр
1	Компьютер dell	8	ш	8	840,000.0	6,720,000.0	6,720,000.0	-	хард сэнс гэмтсэн	актлах	татах
2	Компьютер dell	8	ш	1	700,000.0	700,000.0	700,000.0	-	хард эвдэрсэн	актлах	татах
3	Үзель	8	ш	1	2,500,000.0	2,500,000.0	2,500,000.0	-	тэжээлийн блок эвдэрсэн	актлах	татах
4	Оёдлын машин	8	ш	12	177,600.0	2,131,200.0	2,131,200.0	-	эвдэрсэн	актлах	татах
5	Телевизор	8	ш	1	600,000.0	600,000.0	600,000.0	-	төв схем шатсан	актлах	татах
6	Үлээвэр даралтат хөгжим	7	ш	14	45,000.0	630,000.0	630,000.0	-	эвдэрсэн ашиглах боломжгүй	актлах	татах
Тоног төхөөрөмжийн дүн						13,281,200.0					
Данснаас хасах хөрөнгийн нийт дүн				37		<b>13,281,200.0</b>					
Үүнээс татан төвлөрүүлэх хөрөнгө						13,281,200.0					
Актлах хөрөнгө											